

Хүүхдэд зориулсан Библи танилцуулж байна

Есүс шуургыг намдаасан нь



Зохиогч: Edward Hughes
Зураглаач: Janie Forest

Орчуулсан: Damdin Horolsuren
Найруулсан: Ruth Klassen

Түүх 48/60

www.M1914.org

Bible for Children, PO Box 3, Winnipeg, MB R3C 2G1 Canada

Зөвшөөрөл: Та энэ бүтээлийг хувилах хуулах эрхтэй харин худалдахыг хориглоно.

Монгол хэл

Mongolian

Есүс болон түүний дагалдагч нар завин дээр байх үед хүчтэй шуурга ирэв. Шуурга хүчтэйгээр Галил тэнгисийг ташуурдав. Энэ төрлийн шуурганд завь живж болох байлаа.

Шуурганаас болж дагалдагч нар айдаст автжээ. Далайн давлагаа завийг бүрхэж уусаар дүүргэв. Харин Есүс энэ шуурганд унтаж байлаа.



1



2

Дагалдагч нар Есүсийг сэрээхээр “Багшаа Багшаа бид үхэх нь” хэмээн хашхирав.




3

“Та нар юунд ингэтлээ айна вэ итгэл багатай хүмүүсээ?” Хэмээн Есүс дагалдагч нараасаа асуулаа. Тэгээд Есүс салхинд намдахыг тушаав ... бас Есүс шуурганд намж чимээгүй бол хэмээн тушаав.



4

Салхи намдаж ... тэнгис нам гүм болов. Дагалдагч нар “Энэ хүн хэн болоод салхи тэнгис хүртэл түүнд захирагддаг билээ” хэмээн шивнэлдэж байв.



5

Хэд хоногийн дараа, Есүс бас л завгүй байлаа. Бараг 5000 орчим хүн Түүнийг цөлөрхөг нутаг хүртэл дагаж иржээ.




6

Бурханы хүчээр Есүс бүх хүнийг нэгэн бяцхан хүүгийн өдрийн хоолоор бүх хүнийг хооллосон юм. Орой болж Есүс хүмүүсийг явуулав.



7

Дагалдагч нар ч явцгаав. Есүс тэднийг завин дээр суулгаад Галил тэнгисийн нөгөө эрэг уруу өөрийнхөө өмнө явуулав.



8



Тэр хурсан олныг явуулсны дараа ганцаараа залбирахаар уул өөд гарав. Орой болоход Тэр тэнд ганцаараа байлаа.

9



Нууранд дагалдагчид салхинд туугдан байв. Тэд хэдийгээр сэлүүрдэж байсан ч салхи тэднийг эргээс холдуулж байв.

10



Дагалдагч нар энэ явдал тэдэнд маш том гэнэтийн бэлэг барина гэж бодоогүй байлаа.

11



Үүрийн гурваас зургаан цагийн хооронд нуурын дунд ямар нэг юм байгааг дагалдагч нар хараад тэд айдаст автаж “Энэ хий үзэгдэл байна!”

12



хэмээн тэд хашхиралдав. Харин тэр бол тэдний Эзэн Есүс байсан бөгөөд тэднийг чиглэн усан дээгүүр алхаж байв.

13



“Зоригтой бай!” хэмээн Есүс тэдэнд хэлэв. “Би байна бүү ай” гэв. Петр Түүнд “Эзэн хэрэв Та мөн юм бол усан дээгүүр алхаж Өөр уруу тань ирэхийг надад тушаагаач” гэв.

14

Есүс “Ир” гэлээ. Петр зоригтойгоор завинаасаа гарч усан дээргүүр алхан Есүс уруу явав.



15

Харин Петр салхи хараад айн живж эхлэв. Тэгээд “Эээн, намайг авраач гэж орилов.”



16

Есүс тэр даруй гараа сунган, түүнийг зууран “Бага итгэлт минь, чи юунд эргэлзэнэ вэ?” гэж асуув. Тэгээд Петр болон Эээн Есүс хоёрыг завинд гарахад салхи зогсов.



17

Завин дээр байсан хүмүүс Есүст мөргөж “Та бол үнэхээр Бурханы Хүү мөн” гэгцгээв.



18

Есүс шуургыг намдаасан нь
Бурханы үг Библээс авсан түүх
Матай 8, Матай 14, Марк 4, Лук8

"Таны үгсийн тунхаглал гэгээрүүлдэг."
Дуулал 119:130

Бурхны гэм гэж нэрлэдэг муу зүйлийг бид хийдгийг Бурхан сайн мэднэ. Гэмийн шийтгэл нь үхэл юм.

Бурхан бидэнд маш их хайртай Тэрээр өөрийн хүү Есүсийг бидний гэмийн төлөөс болгон загалмайн үхэлд тушаасан. Есүс дахин амилж мөнхийн улсдаа буцсан! Одоо Бурхан бидний гэмийг уучилж чадна.

Хэрвээ та гэмээсээ эргэхийг хүсвэл, Бурханд хандан ийнхүү хэлээрэй: Бурхан минь ээ, Би Есүс миний төлөө үхээд дахин амилсан гэдэгт итгэж байна. Миний амьдралд орж ирээд миний гэмийг уучлаач тэгээд би шинэ амьдралаар амьдарч дараа нь тантай хамт мөнхөд амьдрах болно.

Таны хүүхэд шиг Таны төлөө амьдрахад туслаач.

Амен Иохан 3:16

Библи уншиж өдөр бүр Бурхантай ярилцаарай!